

НАЙРУУЛГА БА АФОРИЗМЫН СЭТГЭЛГЭЭ

Ж.Бат-Ирээдүй
/МУИС/

Найруулга зүй гэгч юу болох талаар олон талаас нь тайлбарлаж бичдэг. Найруулга зүйг түүхэн үүднээс авч үзвэл эхнээсээ зөвхөн уран зохиол болон илтгэх урлагтай холбож тайлбарлаж ирсэн байдаг. Тийм учраас илтгэх урлаг бол тухайн цаг үедээ маш хүчтэй хөгжиж байсан юм.

Найруулга зүй гэж юу болох талаар эрдэмтэн судлаач бүр янз бүрээр тодорхойлдог. Олон хүний бичсэн тодорхойлолт дундаас ажиглан үзвээс санаа бодлоо зөв, оновчтой, эмх цэгцтэй, уран яруу, энгийн ойлгомжтой, тодорхой илэрхийлэх арга бол найруулга бөгөөд үүнийг судлах нь найруулга зүй юм. Найруулга гэхээр ганц бичих буюу найруулах хэлний тухай бус дээр дурдсанчлан ярих буюу уран илтгэх тухай ч багтах нь мэдээж хэрэг билээ. Судлаач Г.Сүхбатын тодорхойлсоноор найруулга зүйг олон талаас нь авч үзвэл найруулга зүй гэдэг бол “нэгдүгээрт уран зохиолын яруу хэрэглүүрийг судлах ухаан, хоёрдугаарт, хэлний хэрэглүүрийг зөв зохистой хэрэглэх ухаан, гуравдугаарт, хэлний прагматик олон үүргээс хамааран хэлний хэрэглүүрийг харилцааны янз бүрийн хүрээнд ашиглах, хэрэглэх ухаан, дөрөвдүгээрт, хэлний хэрэглүүрийн хувилбарын тухай түүнээс зөв сонгох тухай ухаан”¹ гэсэн маш өргөн утгаар ойлгох ёстой юм. Өөрөөр хэлбэл найруулгыг зөвхөн зөв бичих тухай биш, найруулгын энгийн алдаануудын тухай биш утга зохиолын сэтгэлгээний маш өргөн талбарт авч үзэх ёстой өргөн ойлголт билээ.

Монголын нэрт зохиолч Дармын Батбаяр “Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц” номдоо “Урлаг уран зохиол бол үлэмж сайхныг бүтээх үйл. Алив сайхан юмны хэрхэн, яагаад сайхан байгаа нь нууц байдаг. Энэ утгаараа зохиол бүтээл туурвина гэдэг бол нууцыг бүтээхүй юм. Уран зохиолыг бичих тусгай жор байдаггүй гэдэг. Нийтээр үүнийг баримталдаг. Ямарваа тодорхой уран бүтээлийг хэрхэн яаж бүтээх бэлэн жор байдаггүй нь үнэн ч, уран бүтээлийг бүтээдэг ерөнхий зүй тогтол байдаг гэдэгт бат итгэсэн учраас би энэхүү зүй тогтлын эрэлд гарч, эрсэнийхээ хүчинд тодорхой зүй тогтлыг олж, түүнээ тодорхой зүй тогтлоор байрлуулан бичсэн юм. ...”² хэмээн бичжээ. Тэгэхээр тэрхүү үлэмж сайхныг хэрхэн бүтээх тухай яриа нь бидний найруулгын сэтгэлгээ болон хэрхэн зөв оновчтой найруулах тухай өргөн асуудал байх болно. Хэдийгээр энэ нь зөвхөн бичгийн уран зохиолын хувьд ярьж байгаа ч өргөн олон түмэнд хамгийн их нөлөөлдөг

¹ Г.Сүхбат нар, (2007) “Найруулах эрдэм, хэл ярианы соёл 1”, 22 дах тал.

² Д.Батбаяр, (2007) “Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц”Уб.,

найруулга бол сэтгэлгээний зөв утга учиртай, бичгийн буюу хэм хэмжээг сахисан зөв оновчтой найруулах асуудал юм.

Хэлний зөв оновчтой байх тухай асуудал бол найруулгын шаардлагын хүрээнд авч үздэг тодорхой асуудлуудын нэг юм. Проф. Ц.Сүхбаатар “Хэл ярианы ямарваа найруулга, тэр ч байтугай хүн бүрийн найруулга өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Гэхдээ найруулга зүйн нэгэн ерөнхий шаардлагыг заавал хангасан байх учиртай байдаг гээд хамгийн чухал шаардлагуудад “өгүүлж байгаа зүйл тодорхой байх, үг хэллэг оновчтой байх, үгийн баялаг арвин байх, нурушсан зүйлгүй товч байх, өөрийн гэсэн арга барилтай байх, уншигчдад нэгэн цэгц ойлголт өгөх, гоёж чамирхсан зүйлгүй энгийн байх, ойлгомжтой, сонирхолтой, яруу сонсголонтой, гоо зүйн хэм хэмжээн харгалзсан байх”³ –ыг багтаасан байдаг. Харин энэхүү ончлох-ыг зөвхөн нэг найруулгын шаардлага болгоод орхих бие ерөөсөө аливаа урт богино найруулгад утгыг хэрхэн ончлох тухай сэтгэлгээний асуудал болгон үзэлтэй. Бид энэ хичээлд энэ тухай л авч үзэх юм.

Найруулгын хувьд зөв байх гэдэгт бид хэлний хэм хэмжээний тухай ойлголтыг авч үзэх ёстой байх. Зөв байна гэдэг нь тэр хэлний хэм хэмжээг чиг баримжаа болгож мөрдөж дагана гэсэн үг юм. Хэлний хэм хэмжээ гэдэг маань аливаа хэлний хувьд нийгэм хамт олноороо нэгэн мөр ерөнхий үлгэр загвар болгон баримталж байгаа хэлний тодорхой загвар билээ. Эрдэмтэд найруулгын тухай ярихдаа хэлний хэм хэмжээний тухай заавал дурддаг. Тухайлбал, проф. Ц.Сүхбаатар, “Найруулга зүй хүний бодол санаа, юм үзэгдлийг хэрхэн уран яруу товч тодорхой цэгцтэй чадамгай илэрхийлэх аргыг олон зорилгоор хэлэнд байгаа тэрхүү учир зорилгод нийцэхүйц арга хэрэглүүрийг задлан шинжилж, нягтлан тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, хэлний хэм хэмжээний хүрээнд хэрхэн зөв товч тодорхой ойлгомжтой хэлж ярьж бичиж туурвиж болохыг судалдаг гэсэн үг”⁴ гэж бичсэн бол судлаач Б.Бямбадорж, “Хүний яриа болон бичгийн авиа, үсэг, дуудлага, бичлэг, үгийн утга, хэлбэр бүтэц, хувилал, өгүүлбэрийн утга санаа, бүтэц, дараалал, найруулгын төрөл зүйлийн онцлог аль ч талаараа алдаа дутагдалгүй байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл зөв дуудах зүй, үсэг зүй, хэл зүй буюу үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүйн ухааны үүднээс зөв тэдгээрийн хэм хэмжээ, жам ёсонд нийцсэн байх шаардлага юм. Хүний яриа, бичиг, энэ бүх талаараа зөв байхгүй бол бид санаа бодлоо эмх цэгцтэй, учир утга төгс илэрхийлж бусдад нэвтрүүлэх аргагүй болно.”⁵ хэмээн хэлний хэм хэмжээ гэдэг ойлголтыг хэл шинжлэлийн бүхий салбараас зөв тэгш хэрэглэхгүйгээр сайн найруулга болох боломжгүйг дурдан бичжээ.

Найруулгын оновчтой байх тухайд энэ бол зөвхөн гадаад үг хэллэгийн орчуулгын оновчтой байх тухай асуудал бус харин тухайн санааг илэрхийлэх арга маяг нь хэр оновчтой байх тухай ч багтах ёстой асуудал гэж үзэж болно. Монгол хэл судлаач зарим хүмүүс найруулгын оновчтой байхыг зөвхөн орчуулгатай холбож тайлбарласан нь учир дутагдалтай билээ. Оновчтой үг хэлэхийн тул утга санаа тодорхой болох учиртай. Францын нэрт яруу найрагч классизмын онолч Н.Буало нэгэн шүлэгтээ, “Утга санааг урдаар бод, тэгээд бич. Угаас хэлэх гэсэн юм

³ Ц.Сүхбаатар, (2009) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,42-43 дахь тал.

⁴ Ц.Сүхбаатар, (2009) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,

⁵ Б.Бямбадорж, (2014) “Монгол хэлний найруулга зүй”, Уб., 38 дахь тал.

чинь тодорхой бус бол учир утгатай үг эрээд нэмэргүй ээ, ухаан бодолд утга санаа тунараад ирвэл уран яруу үг урсаад ирнэ ээ танд” хэмээн бичсэн нь сэтгэлгээнд утга санаа төвлөрөн үүсэхэд уран яруу үг аяндаа урсаж гарна гэдгийг хэлсэн хэрэг байна. Тийм учраас сэтгэхүй ямар байна хэл тийм байна гэсэн үг бөгөөд хэлний хэр ончтой байх нь сэтгэхүйгээс шалтгаалдаг. Гэвч монгол хүмүүс яг энүүхэн энд байна хэлж чадахгүй байна гэж их хэлдэг энэ нь үнэн чанартаа цаад сэтгэхүйдээ хангалттай төвлөрч боловсорч чадаагүй байгаа хэрэг юм.

Одоо онч буюу ончлох сэтгэлгээний тухай дэлгэрүүлэн үзье. Аливаа зүйлийг хүнд хүргэхийн тулд, хэлэхийн тулд үгээр илэрхийлж бичих юм уу ярих шаардлагатай болно. Асуудлыг хэдий чинээ уран яруу ончтой илэрхийлнэ төдий чинээ хүнд хүрнэ. Тийм учраас уран зохиолын төрөл бүрийн хэлбэрээс богино хэлбэрээр ончтой зөв илэрхийлэх нь ямар ч цаг үед чухал байсаар ирсэн одоо ч хэвээр байна. Ялангуяа монгол ардын аман зохиол ийм төрлөөр баян бөгөөд үүнийг нүүдэлчний сэтгэлгээний онцлог, ахуй байдал зэрэг олон зүйлтэй холбон тайлбарласан зүйл их байдаг билээ. Үүнд монгол ардын оньсого, монгол ардын зүйр цэцэн үг, өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэг, ардын дууны яруу найраг, мөр бадаг гээд бүгд багтах учиртай.

Монгол хэлний найруулгын уламжлалыг бид нэн эртний үеэс өвлөн уламжилж ирсэн. Эртний мэргэдээс авахуулаад өнөөдрийн бидний үед хүртэл найруулгад суралцах гурван чухал үндэс бол авьяас билиг, эрдэм мэдлэг, уйгагүй хөдөлмөр гэж үзсээр байна. Арван есдүгээр зууны Монгол утга зохиолын онолч Агваантүвдэн бээр “Зохист аялгууны толийн тогтоосон тэмдэглэл дурдлыг тодруулагч” номдоо “Үг утга хоёулаа яруу аялгуу сайхан төгсвөөс бал бурам мэт яруу сайхан амтаараа сэтгэлийг баясгана. Яруу найраг лугаа нөхөрлөх нь үзэсгэлэнт залуу хүүхэнтэй ханилсан идэр мэт зрхэнд баяртай, биед жаргалтай. Сэтгэлийн далайд эрдмийн лянхуаг дэлгэрүүлэхийг хүсэвч, яруу найргийн нарны гэрлээр эс тэтгэвээс мэргэдийн сэтгэл зохист гэсэн цэцэг хаанаас мишээх вэ” гэж бичжээ.

Монголчууд бол ончлон сэтгэдэг ард түмэн гэдэг нь ардын аман зохиол, зүйр цэцэн үг, ардын дуу хөгжмийн үг хэллэг, үлгэр домог, оньсого, туульс, хаад ноёдын зарлиг, захиа, даалгавар, элчийн үг хэллэг, дуун бариулах арга зэрэг олон зүйлээр батлагдах бөгөөд энэ бүхэнд хэлсэн, бичсэн, тэмдэглэсэн аман яруу найргийн жишээ баримтууд нь монголын эртний уран зохиол, түүх, соёл, бичгийн гайхамшигт өв болсон “Монголын нууц товчоон”, “Чингисийн билэг сургаал”, “Аргусан хуурчийн домог”, “Өнчин хүүгийн цэцэлсэн шашдир”, “Хоёр загалын тууж”, “Алтан ордны үйсэн дээрх бичээс”, “Оюун түлхүүр”, “Субашид”, “Ардыг тэжээхүй рашааны дусал”, “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээх сургаал”, “Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг”, “Тоть шувууны сургаал” зэрэг утга зохиолын бүтээлүүдэд уламжлагдан ирсэнийг бид мэднэ. Сургаалын шүлэг яруу найраг зохиол нь тэр чигээрээ цэцлэн ончилсон сэтгэлгээний баримт болох бөгөөд Дулдуйтын Равжаагийн “Бурхан ч сэтгэлээс гарна, буг ч сэтгэлээс бүтнэ, буян хилэнц сэтгэлээс булт хоосон сэтгэлд буй” гэх буюу Нагаржунайгийн “Ардыг тэжээхүй рашааны дусал” зохиолд буй “Учиргүй бусдын гэмийг өгүүлж бүү үйлд, урьд авсаар бусдын гэмийг хэлбэл удалгүй гэдрэг өөрөө хэлэгдэхүй болох нь ухамсаргүй эхнэр үнэгэнд

нь хэлэгдсэн мэт”⁶ хэмээн цэцэлсэн нь бүгд аливаа зүйлийг өөрөөс бүү зайлуулж, өрөөл бүү чих, өрөөлийг бүү дайрч давшил, өөрийнхөө сайн мууг эхлээд бод гэсэн шиг утга санаа илэрхийлж байна гэж ойлгож болно. Ийнхүү монголын үе үеийн онч мэргэн сургаалтны үг хэллэгийг ажиглахуй З.Агваанбалдангийн “Бүхний суурь хэмээх тийн мэдэлд агуулагдсан хамгийг айлдагч мөнх авьяас боловсорсноос ертөнц тэргүүтэн хамаг юм буй болдог”, Инжинашийн “Нэгэн үзүүрт сэтгэлээр эцэст хүрнэ”, “Хэлсэн бүхэн худал, хийсэн бүхэн үнэн”, “Мянган оны учир шалтгааныг бийр бэхсээс асууж, мяралзан эрээлжлэх үйл явдлыг судар бичиг лүгээ хэлэлцмүй.” зэрэг онч үгсийг хэлсэн нь хүний амьдралын утга учир, сэтгэхүй, түүх намтраа мэдэж танихын утга учрыг таниулан сургасан аястай байна. Энд жишээ болгон Ванчинбалын Инжиннашийн "Нойр гэгч биеийг тэжээх бөгөөтөл унтаж хэтэрвэл өвчин болно. Жаргал гэгч хүний эрэлт бөгөөтөл жаргал хэтэрвэл зовлон ирнэ." хэмээх онч (мэргэн) үгийн утгыг задлан тайлбарласан байдлыг авч үзье. Энэхүү онч үг нь өгүүлбэр зүйн хувьд тус бүр ижил бүтэц, байгууламжтай холимог нийлмэл бүтэцтэй хэлц өгүүлбэр бөгөөд утгын хувьд авч үзвэл нойр бол хүний алдагдсан эрчим хүчийг нөхдөг, биеийн алжаал ядаргааг тайлж эрүүл байхыг зохицуулж байдаг биологийн амин чухал зүйл бөгөөд нойр хэтэрвэл бүр өвчин болдог гэсэн үнэнийг ард түмэн амьдралынхаа ажиглалт, туршлагаар шалгаж нотолсон үнэн билээ. Их нойртой хүн л их залхуу байдаг, нойрыг унтаж бардаггүй, сэрж бардаг гэсэн ардын мэргэн үг бий.

Орчин үеийн утга зохиол, соёл иргэншлийн түүчээ болсон нэртэй эрдэмтэд, уран бүтээлчид Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Д.Нацагдорж, Ш.Лувсанвандан нарын зэрэг хүмүүсийн хэлсэн үг цагийн шалгуурыг даван онч үг буюу афоризм болж нийгэмд “мөнхрөн үлдэх” нь их байдаг. Тэд хүний ажил амьдралын тухай, амьдралын мөнх бусын тухай, цаг хугацааны тухай, хайр сэтгэлийн тухай, найз нөхөрлөлийн тухай, шударга ёсны тухай, эрх чөлөө эв нэгдлийн тухай бичсэн нь түүхийн явцад гайхамшигтэй сайхан онч мэргэн үг болон хувирсан байдаг. Тухайлбал, Ц.Дамдинсүрэнгийн “Номын утга тэнгэр мэт агуу, дэлхий мэт өргөн, далай мэт гүн юм. Номыг унших нь тэнгэрт нисэж, дэлхийг тойрч, далайд шумбах мэт.”, Д.Нацагдоржийн “Эрүүл явбал улсын наадам үзнэ.”, “Өсөхөөс сурсан үндэсний хэл, мартаж болшгүй соёл”, Б.Ринчений “Аяа, мунхагуудын дунд суухад нас даан ч урт, аяа мундашгүй эрдэм сурахад нас даан ч богино.”, Ч.Лодойдамбын “Сайхан хайр байдаг юм шүү олдвол алдаж л болохгүй.” гэх зэрэг онч үгс буюу афоризм байдгийг мэдэхгүй хүн бараг үгүй.

Гэтэл хүн өөрөө тэр бүр өөрийгөө анзаардаггүй болохоос биш афоризм хэлье гэж бодоогүй байхдаа үгийн хачирт афоризм хэлж л байдаг байна. Бүр сэтгэлгээний дасгал болгон зориуд зохиож хэлэх хүмүүс ялангуяа зохиолч, сэтгүүлч, улс төрч, нийгмийн зүтгэлтэн нарын дунд их байдаг. Афоризм гэдэг бол хүний бүтээлч сэтгэлгээ, амьдралын туршлага, эрдэм боловсрол зэрэг олон зүйлээс үүдэн бий болж байдаг “нийгэмд үлдэж тогтох чанартай, нийгмийн гишүүдэд хандсан үг хэллэг” юм. Өнөөдөр жишээлбэл Монголын нийгэмд зориуд афоризм буюу онч үг дагнан бичдэг зохиолч, яруу найрагч, нийгэм улс төрийн зүтгэлтэн олон бий. Тухайлбал, улс төрч Ц.Элбэгдорж, Н.Энхбаяр, зохиолч Д.Батбаяр, Л.Дашням,

⁶ Л.Хүрэлбаатар, “Огторгуйн цагаан гарди”, Уб., 1996, 102 дах тал.

Д.Урианхай, До.Цэнджав, Б.Лхагвасүрэн, Ү.Хүрэлбаатар, нийтлэлч Б.Баабар, их эмч М.Шагдарсүрэн, Д.Өлзийбат зэрэг хэлсэн үг болгон нь бараг онч үг болж хувирч байдаг ийм бодгаль хүмүүс манай нийгэмд олон байна. Сүүлийн үед онч үгс буюу афоризмаар дагнасан болон дайвар бүтээлүүд ч хэвлүүлсээр байна. Тухайлбал, Н.Өлзийбатын “Оногдохуйн тавилан” (2006), Л.Дашнямын “Бор дэвтэр” (2005), Б.Лхагвасүрэнгийн зохиолын түүврүүд, Д.Урианхайн түүвэр, Ү.Хүрэлбаатарын “Чөдөр гурвалжин, Тархины фитнес, Гандирсан”, (2015) До.Цэнджавын “Мянган цэн үг” (2010), “Асар тэнгэрийн дор”, Б.Лхагвасүрэнгийн “Ангир уураг” (1991), Ж.Бат-Ирээдүйн “Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, түүний үг сэтгэлгээний ертөнц” (2011), Ж.Бат-Ирээдүйн “Ирээдүйн ертөнц” (2010), “Цахиагийн Элбэгдоржийн онч үгс 1”(2012) зэрэг бүтээлүүдийг энд жишээлж болно. Эдгээр номууд болон бусад эх сурвалжаас авсан онч үгийн сэтгэлгээг ажиглан үзээд монгол онч үгийн сэтгэлгээний талаар судалгаа хийх, түүний утга уянга, найруулах ур маяг, сэтгэлгээ зэрэг олон талаас нь тусгайлан судлан шинжлэх цаг нэгэнт болсныг бас дурдалтай. Мөн нийгэмд нэр төр нь алдаршсан хүмүүсээс эхлээд энгийн хүмүүсийн онч үгсийг түүвэрлэн афоризмоор дагнасан бүтээл гаргасан туршлага ч байна. Тухайлбал Д.Боролзой, Д.Анхбаяр нарын эмхэтгэсэн “Энгийнээс энгүй хүмүүсийн үнэн үгс” номыг энд дурдаж болох бөгөөд эл номд Платоны “Огт юу ч мэдэхгүй байна гэдэг тийм ч айхтар хортой зүйл биш, харин дутуу дулимаг эзэмшсэн мэдлэг л түүнээс аюултай”, Парис Хилтоны “Өөрийнхөө хүссэн чиг хандлагаараа л хувцасла. Амьдрал дэндүү богинохон. Бидэнд бусдаас ичиж эмээх цаг зав ч олдохгүй шүү”, Дашийн Мундаа “Хамгийн зөв зам бол гэртээ харих зам”, Б.Тунгалагийн “Хэчнээн ядуу хүнд ч савангийн мөнгө олддог л байхгүй юу” гэх зэрэг энгүйгээс энгийн хүмүүсийн ... хий хоосон цэцэрхэл биш, цэцэн мэргэн үгийн цуглуулга бүр ч биш”⁷ харин ард түмний дунд афоризм болсон олон үгс эл номд орсон байна.

Өнөөгийн орчин үеийн онч сэтгэлгээ буюу афоризмын талаар зарим судлаачдын байр суурийг товчхон авч үзье.Тухайлбал орчин цагийн онч үг хэллэгийн тухай Төрийн соёрхолт, судлаач Цэвэлийн Шагдарсүрэн бээр, “... тийм үгийн олон түмнийг дагуулан ам дамжих хүч нь тухайн “зохиогчийн” ухааны цар, хэл найруулгын торгон мэдрэмжтэй нь шууд холбоотой байх тул санасан бүхэн түүний зохиогч болж чаддаггүй байна. ...Европ дахинаа афоризм буюу quotation хэмээх оносон үг хэллэг гэдэг бол хоёр чухагийн нэгдэл. Нэгэн талаас, утга санааны хувьд ертөнцийн нийлэг үнэн мөн хийгээд учир холбогдлын төгс төгөлдөр илэрхийлэл, нөгөө талаас хэл найруулгын хувьд илүү дутуугүй, товч тодорхой туйл, өөрөөр хэлбэл утга санаа хийгээд хэл найруулга төгс төгөлдөр байхын аль нэг нь дутагдах бөгөөс түмний санаанд хүрч сэтгэлд хоногшин, ам дамжина гэж үгүй. Хэн бүхний хэлсэн бүхэн “ёстой” оносон үг хэллэг болж чаддаггүй, тэгээд цөөн байдгийн цаад учир тэр.”⁸ хэмээн бичжээ.

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, эрдэмтэн, зохиолч Долгорын Цэнджавын “Мянган цэн үг” номын удиртгалд профессор Ж.Баянсан бичихдээ, “До.

⁷ Д.Боролзой, Д.Анхбаяр, “Энгийнээс энгүй хүмүүсийн үнэн үгс”, Уб., 2012, 4-5 дах тал.

⁸ Ц.Шагдарсүрэн, “Мянган цэн үг” хэмээх номд оршил бичихийн учир”, До.Цэнджав, (2010) “Мянган цэн үг”, Уб., 8 дах тал

Цэнджавын энэ “цэн үг” гэдэг нь монгол ардын зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэг зэрэг хэлж сэтгэх дээд эрэмбийн хийсвэрлэлийн үлгэр жишээг боловсролоо болгосон уран зохиолчийн туурвил зүйн сэтгэлгээнийх нь нэгэн өвөрмөц илэрхийлэл мөн гэж хэлж болно.” хэмээн тэмдэглэсэн байдаг юм. Энэ бол юу гэсэн үг вэ гэмээн түүний нэрлэж буй цэн үг буюу афоризм бол “хүний сэтгэлгээний хийсвэрлэлийн хамгийн дээж буюу дээд зэргийн сэтгэлгээний үр дүн” гэж хэлж байгаатай агаар нэгэн хэмээн ойлгож байна. Профессор Ж.Баянсан энэ номд цааш нь хэлний авалцуулан холбох сэтгэхүй буюу хэлээр үүтгэн цогцлоох сэтгэхүй-н тухай үзэл баримтлалыг зохиолч До.Цэнджавын хэлсэн цэн үгийг түшиглэн гадаадын нэртэй сэтгэгч нарийн хэлсэн онч үгээр авалцуулан тайлбарласан байдаг юм. Жишээ нь тэрбээр бичихдээ, “Аливаа хэлний метафор, өвөрмөц хэллэг, зүйр цэцэн үг зэрэг тогтвортой хэллэгийн зүйлс нь цөм энэхүү “хэлээр үүтгэн цогцлоох” сэтгэхүйн үйл ажиллагааны үр дүн болдог. Сэтгэхүйн энэ хэлбэрийг До.Цэнджавын энэ бүтээлээс тодорхой ажиглаж болохоор байна. Жишээлбэл “Холын бурхан тус хүргэж дийлэхгүй үед, ойрын чөтгөр дэм болно.” гэсэн нь монгол ардын “Хүний газрын бурхнаас өөрийн газрын чөтгөр дээр” гэх буюу “харийн өдрөөс халууны шөнө дээр” гэдэг уламжлалт хэллэгтэй утга санаагаараа дүйх хэллэг байна. Эдгээрийг хооронд нь харьцуулбал холын, хүний хоёр, ойрын өөрийн хоёр тус тус эсрэгцсэн нь сонин байна. Монгол сэтгэлгээний үүднээс Би, Бусад хоёр, (харин би өөрөө гарцаагүй Хүн мөртлөө) Хүний юм, Миний юм хоёрыг тус тус эсрэгцүүлэн ухаардаг нь сонирхолтой билээ. Чингээд өдөр, шөнө хоёр эсрэгцэхдээ өдөр нь эерэг үнэлэмжийн утга тээж, шөнө нь далддаа сөрөг үнэлэмжийн утга агуулдаг учраас харь л бол “сайн”, “гэгээн” өдөр ч гэсэн халууны “муу”, “харанхуй” шөнөөс доор гэсэн үнэлэмжтэй байдаг нь монгол сэтгэлгээний тогтвортой хэв шинжийн нэг юм. Тэгвэл саях ишилсэн цэцэн үгээс зохиолчийн “авалцуулан холбох сэтгэхүйн” онцлог мэдрэгдэж байх шиг байна. Зохиолч, өөр нэг газар “Хамгийн аюултай өвчин бол “Би” гэснийг дээрх тэмдэглэгээний агуулгатай холбон үзэж бас болно. Ер нь ижилдүү агуулгатай өгүүлэмж, төстэй уран дүрслэл уран зохиолд ч, эрдэм шинжилгээний бүтээлд ч дайралдаж л байдаг “бүтээлчээр суралцахуй” хэмээн тайлбарлаад өнгөрдөг нь танин мэдэхүйн хувьсал хөгжилт, уламжлал шинэчлэлийн үүднээс сонирхууштай ч, нягтлууштай ч зүйл байж болох. Тухайлбал, “Кихот ноён”-г зохиосон Мигэль Дэ Сэрвантес “хана туурга ч нүдтэй байдаг” гэсэн цэцэн үгээ монгол ардын “бут буландаа нүдтэй, уул оройдоо нүдтэй” гэдгээс бүтээлчээр суралцсан гэх юм уу, “Талд туссан өглөөний нар, харгана бутадын оройн завсраар үзэсгэлэнт бүсгүйн мөөм шиг булхалзана” гэсэн шиг дүрслэл, “говьд туссан өглөөний нар, хэвтээ тэмээдийн бөхөн дунд хэлгий уураг шиг цэлцэгнэнэ” гэсэн дүрслэл хоёрыг хоёр зохиолчийн нэг бүтээл гэж хэлэх зүрхтэй хүн гарахгүй гэдэгт үл эргэлзэнэ. Тэгвэл В.Шекспирийн “Эргэлзэл бол урвагч мөн” гэсэн цэцэн үгийг яруу илэрхийлэх, сэтгэл оргиох чадамжаар нь До.Цэнджавын “хязгааргүй эрх мэдэл эрх чөлөөн дээр гишгэсэн хөлийн сүүдэр мөн”, “Аз сохор тул хэн рүү очихоо ер мэддэггүй.”, “урт наслах сайхан ч, ухаан урт наслах л улам сайхан”, “замдаа төөрсөн нь биш, зам заасан нь бурууддаг” гэсэн цэцэн хэллэгүүдтэй харьцуулж

үзвэл тун сонин байна.”⁹ гэжээ.

Афоризмын бас нэг онцлог бол үнэнийг ил шууд эсвэл егөө ёж утгаар өгүүлэх чадвар юм. Өөрөөр хэлбэл уран зохиолын төрөл дундаас афоризм бол үнэнийг танин мэдүүлэх хамгийн төд зам мөн гэж хэлэлтэй. Гэвч үнэн гэж юу вэ гэсэн асуулттай холбоотой учраас үүнийг философийн талаас нь авч үзвэл харьцангуй ойлголт юм. Энэ тухай Д.Батбаяр, “Урлаг уран зохиолоос бусад танин мэдэхүйн бүх төрлүүд үнэнийг шууд үгүүлдэг. Энэ нь үнэнийг шууд мэдээд авчих сайн талтай ч үнэнийг эрэхэд оролцох хувь хүний оролцоо хязгаарлагдмал байдаг. Дамаан үнэнийг олохоосоо эрэх нь эрхэм байдаг амьдралд урлаг, уран зохиол шиг чухал нь үгүй. Үнэнийг эрэх нь үнэнийг ойлгох хамгийн дөт зам. Энэ дөт замд уншигч үзэгчийг хүргэхийн тулд урлаг уран зохиол худлыг өгүүлдэг. Худал хэлэх нь уран зохиолын үндсэн арга. Үндсэн арга учраас энэ хэрэглэглэдэггүй, хэрэглэхийг эрхэмлэдэггүй, зайлшгүй хэрэглэх ёстой хэмээх зарчим баримталдаггүй зохиолч уран бүтээл ховор. Жинхэнэ урлаг, уран зохиол чухамхүү үүн дээр л суурилсан байдаг”¹⁰ гэжээ. Ийнхүү үнэнийг урнаар илэрхийлэхийн нэг төрөл нь афоризм буюу онч сэтгэлгээ бөгөөд хэдий чинээ богино байх тусмаа энэхүү утга санааг гаргах ур маяг нь улам нарийн байдаг байна. Тухайлбал, Дарамын Батбаяр гуайн өөрийнх нь зохиосон зарим онч үгсийг авч үзвэл, “Амьдрал гэгч жингийн цуваа. Хэтэрхий хурдан явбал урдхынхаа өсгий дээр гишгэж хилэнг нь хөдөлгөнө, хэтэрхий удаан явбал арын чинь хүн өсгий дээр чинь гишгэж чиний хилэнг хөдөлгөнө.”, “Зайлшгүй ирэхэд бурхан ч чөтгөрийн талд ордог.”, “Ертөнцийн төгс төгөлдөр нь гагцхүү дутуу юмгүй, илүү юмгүй байдаг л оршино.”, “Миний зовлон бусдын зовлонгоос илүү гэж боддогт зовлонгийн хүнд нь оршино.”, “Жигүүр хайх хэрэггүй. Гагцхүү оргилын зүг эцэж цуцахыг умартан авирах хэрэгтэй. Оргилд дөхөх тусам өөртөө жигүүр буйг мэдрэх болно.”,

⁹ Ж.Баянсан, “Мянган цэн буюу арван лан үгийн учиг”, До.Цэнджав, “Мянган цэн үг” Уб., 2010, 13-14 дэх тал.

¹⁰ Д.Батбаяр, (2007) “Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц”, 13-14 дэх тал

НОМЗҮЙ

Судалгааны бүтээлүүд:

1. Д.Отгонсүрэн, (1975) “Монгол хэлний найруулга зүй” Уб.,
2. Ц.Сүхбаатар, (1998) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,
3. Д.Отгонсүрэн, (1998) “Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй”, Уб.,
4. Ц.Сүхбаатар, (2003) “Монгол хэлний найруулга зүйн нэр томъёоны тайлбар толь”, Уб.,
5. М.Базаррагчаа, (2005) “Монгол хэлний өгүүлбэр судлал, Уб.,
6. Ц.Сүхбаатар, П.Увш, (2004) “Илтгэх урлаг суралцах бичиг”, Уб.,
7. Ц.Сүхбаатар, (2006) “Найруулга зүйн судалбар”, Уб.,
8. Г.Сүхбат нар, (2007) “Найруулах эрдэм хэл ярианы соёл”, Уб.,
9. Ч.Чимэгбаатар, (2011) “Монгол хэлний яруу найруулга 1 Б.Ринчен”, Уб.,
10. Г.Буянтогтох, (2012) “Монгол хэлний чөлөөт найруулга судлалын удиртгал”, Уб.,
11. “Найруулга зүйн тухай ойлголт”, (2012) “Орчин цагийн монгол хэл”, хамтын, МУБИС-ийн МСС-ийн МХШТэнхим, Уб.,
12. Ц.Дашдондов, (2014) “Үзгэн шилбүүр барьж үгийг сүрэг гилж, утгын таяг тулж туулсан он жилүүдийн ойллого”, Уб.,
13. Б.Бямбадорж, (2014) “Монгол хэлний найруулга зүй”, Уб.,
14. “Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг”, (2014), хамтын, Уб.,
15. Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэлбичиг: утга, соёл, хэрэглээ” (2013), Уб.,

Уран зохиолын бүтээлүүд:

1. Д.Батбаяр, “Саахалтын нууранд ангир дуугарна.” Уб., 1990
2. Б.Лхагвасүрэн, “Ангир уураг”, Уб., 1991
3. Н.Өлзийбат, “Оногдохуйн тавилан”, Уб., 2006
4. Л.Дашням, “Оонтий-Моонтий миний мөнхий тоолол”, Уб., 2007
5. Л.Дашням, “Бор дэвтэр”, Уб., 2008
6. Ж.Бат-Ирээдүй, “Ирээдүйн ертөнц”, Уб., 2009
7. До.Цэнджав, “Мянган цэн үг”, Уб., 2010
8. Д.Боролзой, Д.Анхбаяр, “Энгийнээс энгүй хүмүүсийн үнэн үгс” Уб., 2012
9. Д.Урианхай, “Түүвэр зохиолууд”, УЗСТӨв, Уб., 2013
10. До.Цэнджав, “Асар тэнгэрийн дор: 500 рубай буюу дөрөвтүүд”, Уб.,
11. “Цахиагийн Элбэгдоржийн онч үг 1”, Уб., 2013
12. “Эртний сургаалын зохиолууд”, Болор судар Хэвлэлийн Газар, Уб., 2015